



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: СНАГ-2024/173/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Улаанбаатар хот

2023 он

Санхүү-нийцлийн аудитын газрын захирал,
тэргүүлэх аудитор: Ц.Наранчимэг
Утас: 261665 Цахим хаяг: naranchimegts@audit.gov.mn

Аудитын менежер: С.Нацагдорж
Утас: 260512 Цахим хаяг: Natsagdorjs@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Эрдэнэзул
Утас: 261628 Цахим хаяг: erdenezulb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ
ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Л.БАЯРМАНДАЛ ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:51-26-42-30
E-mail: info@audit.gov.mn

2024.02.23 № 07/334

танай _____-ны № _____-т

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Ашигт малтмал, газрын тосны газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар нийт 1,905,896.8 мянган төгрөгийн зөрчил илэрч, улсын төсвийн орлого дутуу бүрдүүлж, төвлөрүүлсэн, орлогын анхан шатны бүртгэл, ногдуулалтад тавих хяналт сул, сургалтын төлбөрийг суралцагч бүрээр тооцоо үүсгэж хяналт хэрэгжүүлээгүй байгаа нь шинж чанарын хувьд материаллаг, дангаараа буюу эсвэл нийтээр санхүүгийн тайланд материаллаг боловч өргөн тархаагүй, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.2, 41 дүгээр зүйлийн 41.2.1, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 13 дугаар зүйлийн 13.3, 13.4 дэх заалтуудтай нийцээгүй, санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Асуудлыг онцолсон хэсэг

Хайгуулын тусгай зөвшөөрөл олгох сонгон шалгаруулалтыг цахим /tender.gov.mn болон mrgam.gov.mn/ системд бүрэн нэвтрүүлж зохион байгуулснаар төрийн үйлчилгээг ил тод болгон, тайлант онд 2.3 сая гектар бүхий 2450 талбайг зарласнаас 1.1 сая гектар бүхий 209 зөвшөөрөл олгосон байна.

Аудитын гол асуудал

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт улсын төсөвт төвлөрүүлэх болон үйл ажиллагааны орлогыг мөнгөн сууриар бүртгэхээр тусгасан, сургалтын урамшууллын хөрөнгийг хянаж бүртгэх талаар тусгаагүй зэрэг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандарттай нийцээгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Ашигт малтмал, газрын тосны газар нь 2023 онд 2 зорилгын хүрээнд 25 зорилт, 70 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөн 91.3 хувийн биелэлттэй гэж тайлагнасан байна.

Нийт арга хэмжээний 40 арга хэмжээ 100 хувь, 26 арга хэмжээ 70-90 хувь, 3 арга хэмжээ 50 хувийн хэрэгжилттэй гэж тайлагнасан бөгөөд 1 арга хэмжээ хэрэгжээгүй байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.


Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ-НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ



2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	36,330,092,017.13	32,766,307,400.90
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ		522,242,457.17
31200	Банкинд байгаа бэлэн мөнгө		522,242,457.17
31210	Төгрөг		522,242,457.17
31211	Төрийн сангийн харилцах		522,242,457.17
33	АВЛАГА	12,423,303,778.56	8,335,525,364.43
33500	Бусад авлага	12,423,303,778.56	8,335,525,364.43
33510	Байгууллагаас авах авлага	12,421,254,038.56	8,334,336,864.43
33520	Хувь хүмүүсээс авах авлага	2,049,740.00	1,188,500.00
34	УРЬДЧИЛГАА	114,753,365.37	89,340,422.37
34600	Урьдчилж гарсан зардал	107,780,076.25	82,969,550.25
34710	Урьдчилгаа тооцоо	6,973,289.12	6,370,872.12
34711	Бараа материал бэлтгэх урьдчилгаа	6,973,289.12	6,370,872.12
35	БАРАА МАТЕРИАЛ	616,644,519.92	643,808,803.65
35300	Бэлэн бүтээгдэхүүн	56,711,840.00	56,542,920.00
35400	Хангамжийн материал	559,932,679.92	587,265,883.65
35410	Бичиг хэргийн материал	14,828,268.32	8,459,400.05
35420	Аж ахуйн материал	523,220,637.26	564,170,978.53
35430	Сэлбэг хэрэгсэл	17,851,899.91	12,994,129.91
35440	Түлш, шатах тослох материал	4,031,874.43	1,641,375.16
36	НӨӨЦИЙН БАРАА	23,175,390,353.28	23,175,390,353.28
36400	Шатахууны нөөц	23,175,390,353.28	23,175,390,353.28
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	5,005,644,179.40	5,166,895,355.95
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	5,005,644,179.40	5,166,895,355.95
39200	Биет хөрөнгө	4,729,026,428.11	4,869,351,478.15
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,042,801,473.59	3,042,801,473.59
39202	Хуримтлагдсан элэгдэл	(356,503,627.68)	(445,074,564.45)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	2,523,408,990.95	2,100,118,849.16
39204	Хуримтлагдсан элэгдэл	(1,897,083,244.84)	(1,459,314,467.56)
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	6,651,183,806.20	6,571,621,522.82
39206	Хуримтлагдсан элэгдэл	(5,752,510,958.94)	(5,434,774,892.29)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	1,036,222,628.42	956,650,779.81
39208	Хуримтлагдсан элэгдэл	(944,509,214.06)	(891,997,162.91)
39214	Бусад үндсэн хөрөнгө	940,674,575.47	956,438,687.47
39215	Хуримтлагдсан элэгдэл	(514,658,001.00)	(527,118,747.49)
39300	Биет бус хөрөнгө	276,617,751.29	297,543,877.80
39301	Програм хангамж	1,600,762,021.05	1,528,437,021.05
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,511,014,509.76)	(1,417,763,383.25)
39303	Бусад биет бус хөрөнгө	186,870,240.00	186,870,240.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	41,335,736,196.53	37,933,202,756.85
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	3,038,284,663.00	207,354,373.01
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	3,038,284,663.00	207,354,373.01
41300	Өглөг	3,038,284,663.00	207,354,373.01
41360	Бусад өглөг	3,038,284,663.00	207,354,373.01
41361	Байгууллагад төлөх өглөг	3,038,284,663.00	207,354,373.01
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	38,297,451,533.53	37,725,848,383.84
51	Засгийн газрын хувь оролцоо	38,297,451,533.53	37,725,848,383.84
51100	Засгийн газрын оруулсан капитал	10,187,812,519.22	10,187,812,519.22
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	10,187,812,519.22	10,187,812,519.22
51200	Хуримтлагдсан үр дүн	25,664,195,630.53	25,092,592,480.84
51210	Өмнөх үеийн үр дүн	25,209,518,272.04	25,664,195,630.53
51220	Тайлант үеийн үр дүн	454,677,358.49	(571,603,149.69)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	2,445,443,383.78	2,445,443,383.78
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	41,335,736,196.53	37,933,202,756.85

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	222,426,698,057.13	414,740,651,897.98
11	ТАТВАРЫН ОРЛОГО	37,573,392,659.22	39,930,409,021.24
118	Бусад татвар, төлбөр, хураамж	37,573,392,659.22	39,930,409,021.24
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	37,573,392,659.22	39,930,409,021.24
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	35,692,118,104.92	36,741,262,474.52
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	1,881,274,554.30	3,189,146,546.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	180,564,691,297.91	369,107,760,976.41
120	Нийтлэг татварын бус орлого	180,564,691,297.91	369,107,760,976.41
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	21,776,327,568.10	63,973,658,194.49
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	18,179,321,608.73	58,962,656,384.17
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,597,005,959.37	5,011,001,810.32
120006	Газрын тосны орлого	158,532,325,661.03	304,157,630,440.70
120009	Бусад орлого	2,154,819.68	579,613,008.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	253,883,249.10	396,859,333.22
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,288,614,100.00	5,702,481,900.33
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,288,614,100.00	5,644,881,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,288,614,100.00	5,644,881,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		57,600,000.33
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		50,000,000.33
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	221,809,828,416.97	415,312,255,047.67
21	УРСГАЛ ЗАРДАЛ	221,809,828,416.97	415,312,255,047.67
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,094,617,451.42	6,930,519,581.53
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,449,777,154.46	3,822,252,722.43
210101	Үндсэн цалин	1,475,818,361.82	1,968,542,469.40
210102	Нэмэгдэл	377,582,516.45	573,979,142.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	271,545,000.00	627,472,000.00
210104	Урамшуулал	169,709,979.92	434,808,795.58
210105	Гэрээт ажлын хөлс	155,121,296.27	217,450,314.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307,647,774.17	480,277,582.74
210201	Тэтгэврийн даатгал	297,036,656.13	329,174,854.64
210202	Тэтгэмжийн даатгал	3,279,458.77	38,680,316.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,956,821.22	30,447,052.00
210204	Ажилгүйдлийн даатгал	488,621.73	7,428,620.88
210205	Эрүүл мэндийн даатгал	4,886,216.32	74,546,739.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,190,738.22	137,096,491.02
210301	Гэрэл, цахилгаан	11,951,492.21	21,769,733.20
210302	Түлш, халаалт	26,308,354.01	28,113,387.31
210303	Цэвэр, бохир ус	5,040,727.00	5,025,370.51
210304	Байрны түрээс	55,890,165.00	82,188,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	172,575,950.02	214,567,609.90
210401	Бичиг хэрэг	36,408,103.26	49,711,323.29
210402	Тээвэр, шатахуун	40,513,689.39	47,081,916.86
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,744,240.19	63,802,266.56

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	412,300.00	202,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	42,497,617.18	53,770,103.19
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	123,956,332.76	111,105,292.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	9,872,684.29	66,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,461,450.00	0
210604	Урсгал засвар	112,622,198.47	111,039,292.58
2107	Томилолт, зочны зардал	152,181,905.75	408,083,323.10
210701	Гадаад албан томилолт	46,507,476.74	239,966,579.10
210702	Дотоод албан томилолт	105,674,429.01	168,116,744.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	949,631,932.70	922,748,317.04
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	884,217,689.70	865,933,527.23
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,070,710.00	1,141,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	22,140,640.00	19,365,490.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,936,706.00	3,347,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,014,782.00	531,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	31,240,000.00	30,295,179.81
210807	Газрын төлбөр	1,538,755.00	171,980.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,472,650.00	1,961,240.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	839,655,663.34	834,388,242.72
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0	1,696,369.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	839,655,663.34	832,691,873.72
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	216,715,210,965.55	408,381,735,466.14
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	0	112,563,709.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	0	112,563,709.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,895,146,877.77	2,065,365,754.77
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,704,962,300.00	1,636,103,396.21
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,106,800.00	72,208,342.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	97,077,777.77	357,054,016.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	214,704,934,136.78	405,508,446,183.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	666,951,658.80	1,376,748,514.82
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	214,037,982,477.98	404,131,697,669.05
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,129,951.00	695,359,818.50
213404	Хөрөнгийн	115,129,951.00	695,359,818.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	616,869,640.16	(571,603,149.69)
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	162,192,281.67	
225001	Үндсэн хөрөнгө, бараа материал худалдсаны гарз	162,192,281.67	
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	454,677,358.49	(571,603,149.69)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	223,291,144,318.03	415,022,279,448.90
11	ТАТВАРЫН ОРЛОГО	37,573,392,659.22	39,930,409,021.24
118	Бусад татвар, төлбөр, хураамж	37,573,392,659.22	39,930,409,021.24
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	37,573,392,659.22	39,930,409,021.24
118002	Ашигт малтмалын хайгуулын болон ашиглалтын тусгай зөвшөөрлийн төлбөр	35,692,118,104.92	36,741,262,474.52
118003	Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөр	1,881,274,554.30	3,189,146,546.72
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	181,429,137,558.81	365,885,471,353.20
120	Нийтлэг татварын бус орлого	181,429,137,558.81	365,885,471,353.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	22,894,926,628.10	61,722,240,912.50
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	19,297,920,668.73	56,711,239,102.18
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,597,005,959.37	5,011,001,810.32
120006	Газрын тосны орлого	158,532,325,661.03	304,157,630,440.70
120009	Бусад орлого	1,885,269.68	5,600,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,288,614,100.00	9,206,399,074.46
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	4,288,614,100.00	9,148,799,074.13
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	4,288,614,100.00	5,644,881,900.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих		3,503,917,174.13
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		57,600,000.33
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		50,000,000.33
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	224,556,939,364.72	414,017,512,201.73
21	УРСГАЛ ЗАРДАЛ	224,556,939,364.72	414,017,512,201.73
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,337,811,225.04	6,213,276,735.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,449,777,153.46	3,821,952,722.43
210101	Үндсэн цалин	1,475,818,343.56	1,968,542,469.40
210102	Нэмэгдэл	377,582,516.45	573,979,142.63
210103	Унаа хоолны хөнгөлөлт	271,545,000.00	627,472,000.00
210104	Урамшуулал	169,709,979.92	434,808,795.58
210105	Гэрээт ажлын хөлс	155,121,313.53	217,150,314.82
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	307,647,774.17	480,277,582.74
210201	Тэтгэврийн даатгал	214,805,874.17	329,174,854.64
210202	Тэтгэмжийн даатгал	23,210,500.00	38,680,316.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	18,232,300.00	30,447,052.00
210204	Ажилгүйдлийн даатгал	4,978,100.00	7,428,620.88
210205	Эрүүл мэндийн даатгал	46,421,000.00	74,546,739.22
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	99,190,738.22	137,096,491.02
210301	Гэрэл, цахилгаан	11,951,492.21	21,769,733.20
210302	Түлш, халаалт	26,308,354.01	28,113,387.31
210303	Цэвэр, бохир ус	5,040,727.00	5,025,370.51
210304	Байрны түрээс	55,890,165.00	82,188,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	196,032,284.19	202,065,226.91
210401	Бичиг хэрэг	44,195,550.00	39,981,230.00
210402	Тээвэр, шатахуун	42,230,000.00	44,089,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	52,744,240.19	63,802,066.56
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	412,300.00	202,000.00

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	56,450,194.00	53,990,930.35
2105	Нормативт зардал	701,000.00	1,040,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	701,000.00	1,040,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	125,417,832.76	231,695,336.58
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,914,184.29	26,917,380.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,461,450.00	21,188,890.00
210604	Урсгал засвар	113,042,198.47	183,589,066.58
2107	Томилолт, зочны зардал	152,181,905.74	408,083,323.10
210701	Гадаад албан томилолт	46,507,476.74	239,966,579.10
210702	Дотоод албан томилолт	105,674,429.00	168,116,744.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	960,739,396.50	924,849,683.81
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	894,390,203.50	868,784,334.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,070,710.00	1,141,700.00
210803	Даатгалын үйлчилгээ	22,140,640.00	19,365,490.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	4,936,706.00	3,347,900.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	1,014,782.00	531,300.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	32,175,000.00	30,295,179.81
210807	Газрын төлбөр	1,538,755.00	171,980.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	2,472,600.00	1,211,800.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	46,123,140.00	6,216,369.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	46,123,140.00	6,216,369.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	220,219,128,139.68	407,804,235,466.14
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг		112,563,709.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг		112,563,709.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,895,146,877.77	2,065,365,754.77
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	1,704,962,300.00	1,636,103,396.21
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	93,106,800.00	72,208,342.56
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	97,077,777.77	357,054,016.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	218,208,851,310.91	405,508,446,183.87
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	666,951,658.80	1,376,748,514.82
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,645,700.33
213306	Улсын төсвийн орлогод төвлөрүүлэх шилжүүлэг	217,541,899,652.11	404,130,051,968.72
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	115,129,951.00	117,859,818.50
213404	Хөрөнгийн	115,129,951.00	117,859,818.50
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	(1,265,795,046.69)	1,004,767,247.17
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	571,746,390.00	482,524,790.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	571,746,390.00	482,524,790.00
2200	Дотоод эх үүсвэрээр	571,746,390.00	482,524,790.00
222001	Тоног төхөөрөмж	369,204,130.00	
223001	Бусад хөрөнгө	10,106,000.00	479,024,790.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	192,436,260.00	3,500,000.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	(571,746,390.00)	(482,524,790.00)
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	(1,837,541,436.69)	522,242,457.17
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	1,837,541,436.69	
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		522,242,457.17

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,209,518,272.04	37,842,774,175.04
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,209,518,272.04	37,842,774,175.04
Тайлант үеийн үр дүн			454,677,358.49	454,677,358.49
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,664,195,630.53	38,297,451,533.53
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,664,195,630.53	38,297,451,533.53
Тайлант үеийн үр дүн	0	0	(571,603,149.69)	(571,603,149.69)
2023 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	10,187,812,519.22	2,445,443,383.78	25,092,592,480.84	37,725,848,383.84

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон
/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	8,093,857,900.00	6,717,109,385.18	(1,376,748,514.82)	83.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	8,093,857,900.00	6,717,109,385.18	(1,376,748,514.82)	83.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,567,801,400.00	5,004,783,546.41	(563,017,853.59)	89.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	4,008,624,600.00	3,604,802,407.61	(403,822,192.39)	89.9
210101	Үндсэн цалин	2,195,008,300.00	1,968,542,469.40	(226,465,830.60)	89.7
210102	Нэмэгдэл	937,793,000.00	573,979,142.63	(363,813,857.37)	61.2
210103	Унаа хоолны хөнгөлөлт	630,312,800.00	627,472,000.00	(2,840,800.00)	99.5
210104	Урамшуулал	245,510,500.00	434,808,795.58	189,298,295.58	177.1
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	504,782,700.00	453,845,774.15	(50,936,925.85)	89.9
210201	Тэтгэврийн даатгал	343,252,300.00	302,743,046.05	(40,509,253.95)	88.2
210202	Тэтгэмжийн даатгал	40,382,600.00	38,680,316.00	(1,702,284.00)	95.8
210203	ҮОМШӨ-ний даатгал	32,306,100.00	30,447,052.00	(1,859,048.00)	94.2
210204	Ажилгүйдлийн даатгал	8,076,500.00	7,428,620.88	(647,879.12)	92.0
210205	Эрүүл мэндийн даатгал	80,765,200.00	74,546,739.22	(6,218,460.78)	92.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	195,063,600.00	123,987,061.93	(71,076,538.07)	63.6
210301	Гэрэл, цахилгаан	41,676,500.00	21,164,603.30	(20,511,896.70)	50.8
210302	Түлш, халаалт	71,717,500.00	26,379,088.12	(45,338,411.88)	36.8
210303	Цэвэр, бохир ус	9,416,200.00	5,025,370.51	(4,390,829.49)	53.4
210304	Байрны түрээс	72,253,400.00	71,418,000.00	(835,400.00)	98.8
2104	Хангамж, бараа материалын зардал	164,754,200.00	161,055,765.91	(3,698,434.09)	97.8
210401	Бичиг хэрэг	26,561,700.00	26,557,210.00	(4,490.00)	100.0
210402	Тээвэр, шатахуун	44,090,000.00	44,089,000.00	(1,000.00)	100.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	59,927,600.00	59,412,632.56	(514,967.44)	99.1
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	202,000.00	202,000.00	0.00	100.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	33,972,900.00	30,794,923.35	(3,177,976.65)	90.6
2105	Нормативт зардал	3,392,400.00	1,040,000.00	(2,352,400.00)	30.7
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	3,392,400.00	1,040,000.00	(2,352,400.00)	30.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	48,318,500.00	29,514,818.00	(18,803,682.00)	61.1
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,383,900.00	6,963,080.00	(3,420,820.00)	67.1
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	36,551,400.00	21,188,890.00	(15,362,510.00)	58.0
210604	Урсгал засвар	1,383,200.00	1,362,848.00	(20,352.00)	98.5
2107	Томилолт, зочны зардал	31,840,500.00	31,736,444.00	(104,056.00)	99.7
210702	Дотоод албан томилолт	31,840,500.00	31,736,444.00	(104,056.00)	99.7
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	589,084,905.81	589,084,905.81	0.00	100.0

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	533,019,556.00	533,019,556.00	0.00	100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,141,700.00	1,141,700.00	0.00	100.0
210803	Даатгалын үйлчилгээ	19,365,490.00	19,365,490.00	0.00	100.0
210804	Тээврийн хэрэгслийн татвар	3,347,900.00	3,347,900.00	0.00	100.0
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	531,300.00	531,300.00	0.00	100.0
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	30,295,179.81	30,295,179.81	0.00	100.0
210807	Газрын төлбөр	171,980.00	171,980.00	0.00	100.0
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	1,211,800.00	1,211,800.00	0.00	100.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	9,716,400.00	9,716,369.00	(31.00)	100.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	9,716,400.00	9,716,369.00	(31.00)	100.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	2,526,056,500.00	1,712,325,838.77	(813,730,661.23)	67.8
2132	Бусад урсгал шилжүүлэг	2,526,056,500.00	1,712,325,838.77	(813,730,661.23)	67.8
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	2,448,976,000.00	1,636,103,396.21	(812,872,603.79)	66.8
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	73,062,300.00	72,208,342.56	(853,957.44)	98.8
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,018,200.00	4,014,100.00	(4,100.00)	99.9
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	6,717,109,385.18	8,093,857,900.00	1,376,748,514.82	120.5
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	5,081,005,988.97	5,644,881,900.00	563,875,911.03	111.1
310001	Улсын төсвөөс санхүүжих	5,081,005,988.97	5,644,881,900.00	563,875,911.03	111.1
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	1,636,103,396.21	2,448,976,000.00	812,872,603.79	149.7
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	1,636,103,396.21	2,448,976,000.00	812,872,603.79	149.7
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	183	183	0	100.0
620001	Удирдах ажилтан	1	1	0	100.0
620002	Гүйцэтгэх ажилтан	140	140	0	100.0
620003	Үйлчлэх ажилтан	25	25	0	100.0
620004	Гэрээт ажилтан	22	22	0	100.0

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН		57,600,000.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ		57,600,000.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ		19,954,300.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал		19,954,300.00
210601	Багаж, техник, хэрэгсэл		19,954,300.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ		37,645,700.33
2132	Бусад урсгал шилжүүлэг		36,000,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал		36,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг		1,645,700.33
213305	нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг		1,645,700.33
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР		57,600,000.33
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого		57,600,000.33
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		7,600,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого		50,000,000.33

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар үлдэх өртөггүй боловч үйл ажиллагаандаа ашиглаж буй үндсэн хөрөнгийг дахин үнэлүүлээгүй алдаа¹г залруулж, дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Аудитаар нийт 1,905,896.8 мянган төгрөгийн зөрчил² илэрснээс, 1,705,777.2 мянган төгрөгийн зөрчилд төлбөрийн акт тогтоож, 200,119.6 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага хүргүүлж, 2 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Үндсэн хөрөнгийн бүртгэлээр үлдэх өртөггүй боловч үйл ажиллагаанд хэвийн ашиглаж буй дахин үнэлүүлэхээр хүлээгдэж байгаа 275 ширхэг 3,282,605.3 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө байна.	1	-			1	-			1	-	1	-
Дүн	1	-			1	-			1	-	1	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс										
	Тоо	Дүн	Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал		
			Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

² Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

Улсын төсвийн хөрөнгөөр хайгуул хийсэн ордын нөхөн төлбөрийн орлогыг 195,354.0 мянган төгрөгөөр, сургалтын урамшууллын 995,506.2 мянган төгрөгөөр, төлөөлөгчийг дэмжих сангийн 514,917.0 мянган төгрөгөөр, нийт 1,705,777.2 мянган төгрөгийг дутуу бүрдүүлж, улсын төсвийн орлогыг дутуу төвлөрүүлсэн.	1	1,705,777.2	1	1,705,777.2									
Улсын төсвийн орлогын анхан шатны бүртгэл хөтлөлт буюу холбогдох мэргэжитнүүдийн гүйцэтгэж буй тухайн жилийн улсын төсвийн орлогын ногдуулалт, төлөлт, тооцооны үлдэгдлийг баталгаажуулах үйл ажиллагаанд удирдлагаас тавих хяналт сул, нягтлан бодох бүртгэлтэй уялдаагүй байна.	1	0.0			1								
Сургалтын зардлыг аккруэл сууриар, суралцагч бүрээр тооцоо үүсгэн бүртгээгүй нь бүртгэлийн зарчмуудтай нийцээгүй, бүртгэлээр тавих хяналтыг сулруулж байна. Тайлант онд нийт урт хугацаагаар гадаад, дотоод суралцагчдын төлбөрт нийт 1,426,318.4 мянган төгрөгийг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн байна.	1	0.0					1						
"Удирдлагын электрон систем"-ийн "Салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний мэдээллийн цахим сангийн хэвийн найдвартай ажиллагааг хангах үйлчилгээ", "Гүйцэтгэлийн удирдлагын мэдээллийн цахим сангийн хэвийн, найдвартай ажиллагааг хангах үйлчилгээ"-г 70.0 сая төгрөгөөр шууд гэрээ байгуулан худалдан авсан байна. Уг системийг эрх бүхий байгууллагаас хүлээн зөвшөөрч, хэрэглээнд нэвтрүүлэхээр зөвшөөрсөн шийдвэргүй, дотоодод хэрэглэж буй АБЛЕ системтэй зарим хэрэглээ давхцсан, цаашид төсвийн урсгал зардлыг жилийн 24.0 сая төгрөгөөр нэмэгдүүлж байна.	1	70,000.0			1	70,000.0							
Газрын тос, уламжлалт бус газрын тосны эрлийг хийж буй 11 хуулийн этгээдтэй байгуулсан "Эрлийн ажил гүйцэтгэх гэрээ" хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа ч 10 хуулийн этгээдээс гэрээний 3 жилийн хугацаагүй дуусаагүй гэх шалтгаанаар авто машин аваагүй байна.	1	0.0					1						
Тайлант онд албан хаагчдын урьдчилан сэргийлэх үзлэгт хамруулсан 47,250.0 мянган төгрөг, лабораторийн шинжилгээний химийн бодис авсан 39,075.6 мянган төгрөг, 15 хуулийн этгээдээс хэвлэл мэдээллийн үйлчилгээ авсан 29,564.0 мянган төгрөг, нийт 115,889.6 мянган төгрөгийн худалдан авалтад гүйцэтгэгчийг харьцуулалтын журмаар сонгон шалгаруулаагүй, шууд гэрээ байгуулан худалдан авалт хийсэн байна.	1	115,889.6			1	115,889.6							

Төрийн хэмнэлтийн тухай хуулийг зөрчиж нийт 14,230.0 мянган төгрөгийг зарцуулсан.	1	14,230.0			1	14,230.0					
Өмнөх оны аудитаар өгсөн дараах зөвлөмжийн хэрэгжилт хангалтгүй байна. Үүнд: 1. 2004-2017 онд хүлээн авсан 7 ширхэг автомашины 2-ыг нь үйл ажиллагаандаа ашиглаж байгаа боловч бүртгэл тайланд тусгаагүй, эвдэрсэн, засвартай 5 ширхэг автомашиныг цаашид хэрхэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй, 2. МУЗГ-ын 2013 оны 291 дүгээр тогтоолоор баталсан "Монгол Улсын Засгийн газраас гэрээлэгч компаниудтай байгуулсан "Бүтээгдэхүүн хуваах гэрээ"-ний дагуу компаниудаас олгодог сургалтын урамшууллын хөрөнгөөр суралцах иргэдийг сонгон шалгаруулах, хөрөнгийг зарцуулах журам"-ын зарим заалтын хэрэгжилт хангалтгүй байна.	1	0.0			1						
Дүн	8	1,905,896.8	1	1,705,777.2	5	200,119.6	2	0.0		0.0	

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитаар илэрсэн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 1 албан шаардлага хүргүүлсэн.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Өмнөх оноос дамжин хэрэгжүүлсэн уул уурхайн геологийн төв лабораторийн тоног төхөөрөмжийн 146,883.0 мянган төгрөгийн үлдэгдэл төлбөрийг Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгаж, батлуулаагүй байна.	1	-			1	-		
Дүн	1	-			1	-		